



ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 01 сарын 12 өдөр

Дугаар А/11

Улаанбаатар хот


Дүрэм батлах тухай

Засгийн газрын агентлагын эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.2, 8.4, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.4-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Уул уурхайн аврах 09 дүгээр ангийн дүрмийг хавсралт ёсоор баталсугай.
2. Дүрмийг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг 09 дүгээр анги (хурандаа Д.Гантулга)-д үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2015 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн "Дүрэм батлах тухай" А/112 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.


ДАРГА,  
БРИГАДЫН ГЕНЕРАЛ



Г.АРИУНБҮЯН



Онцгой байдлын ерөнхий газрын даргын  
2021 оны 01 дүгээр сарын 14-ны өдрийн  
411 дугаар тушаалын хавсралт



## УУЛ УУРХАЙН АВРАХ 09 ДҮГЭЭР АНГИЙН ДҮРЭМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү дүрэм нь Онцгой байдлын ерөнхий газрын дэргэдэх Уул уурхайн аврах 09 дүгээр анги (цаашид "Анги" гэх)-ийн үйл ажиллагааны чиглэл, бүтэц, эрх, үүргийг тодорхойлсон баримт бичиг болно.

1.2. Анги нь уурхай, уулын үйлдвэрлэлийн ослоос урьдчилан сэргийлэх, аврах хор уршгийг арилгах, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйд хяналт тавьж холбогдох хууль тогтоомжийн биелэлтийг хангуулах, сургалт зохион байгуулах төрийн цэргийн байгууллага мөн.

### Хоёр. Үйл ажиллагааны үндсэн зарчим

2.1. Анги нь Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн албаны тухай, Зөрчлийн тухай, Төрийн хяналт шалгалтын тухай, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай, Цэргийн албаны тухай, Гамшгаас хамгаалах тухай, Галын аюулгүй байдлын тухай, Газрын хэвлийн тухай, Ашигт малтмалын тухай хууль, тэдгээртэй нийцүүлэн гаргасан дүрэм, журам, стандарт, зааврыг удирдлага болгон Онцгой байдлын ерөнхий газрын даргын эрхлэх асуудлын хүрээнд уурхай, уулын үйлдвэрлэл эрхэлдэг хуулийн этгээдэд гамшгаас хамгаалах төрийн үйлчилгээг шуурхай хүргэж ажлаа тайлагнана.

#### 2.2. Анги нь:

2.2.1 Урьдчилан сэргийлэх арга хэмжээг төлөвлөх, зохион байгуулах, хяналт тавих;

2.2.2. Аврах, хор уршгийг арилгах үйл ажиллагаанд бэлэн байх;

2.2.3. Нэгдмэл удирдлагатай байх;

2.2.4. Хуулийн этгээдийн аливаа мэдээллийг задруулахгүй байх;

### Гурав. Ангийн эрх

3.1. Уурхай, уулын үйлдвэрүүдэд гамшгаас хамгаалах хяналтын чиглэлээр төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус, гүйцэтгэлийн хяналт шалгалтыг зохион байгуулах;

3.2. Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд уурхай уулын үйлдвэрийн хүч, хэрэгслийг татан оролцуулах;

3.3. Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд шаардлагатай мэдээллийг төрийн байгууллага, хуулийн этгээдээс гаргуулах;

3.4. Уурхай, уулын үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа хуулийн этгээдийн гамшгийн эрсдэлийн үнэлгээ болон гамшгаас хамгаалах төлөвлөгөөний боловсруулалт, хэрэгжилтэд хяналт тавих;

3.5. Гамшгаас хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ уурхай, уулын үйлдвэр, үйлдвэрлэлийн аюултай ажлын байранд саадгүй нэвтрэх;


3.6. Хууль тогтоомжид заасан бусад.

### Дөрөв. Ангийн үүрэг

4.1. Төрийн үйлчилгээг шуурхай хүргэх;

4.2. Гамшиг, аюулт үзэгдэл, ослоос урьдчилан сэргийлэх, эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах үйл ажиллагаанд бэлэн байх;

4.3. Техник, тоног төхөөрөмж, хувцас, багаж хэрэгслийн бэлэн байдлыг хангуулах;



- 4.4. Уурхай, уулын үйлдвэрүүдийн болзошгүй осол /агааргүйдэл, тэсрэлт, уулын чулуулгийн болон хий, тоосны гэнэтийн цохилт, усны цөмрөл, малталтын нурал, хөрсний гулсалт, гал түймэр/-ыг арилгах, түүнээс урьдчилан сэргийлэх;
- 4.5. Гамшиг ослын үед нөлөөллийн бүсийг тогтоож аюулгүй байдлыг хангах;

#### Тав. Ангийн үйл ажиллагаа

- 5.1. Уул уурхайн аврах анги нь эрхлэх асуудлын хүрээнд төрийн болон нутгийн захиргааны, аж ахуйн нэгж байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллана.
- 5.2. Уурхай, уулын үйлдвэрлэлд гамшиг, ослоос урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах чиглэлээр дараах ажлыг гүйцэтгэнэ. Үүнд:
- 5.2.1. Холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нөхцөлд үзлэг шалгалт хийх;
- 5.2.2. Үзүүлэх сургууль, сургалт, дадлага зохион байгуулах; Мэргэжил арга зүйн туслалцаа, дэмжлэг үзүүлэх;
- 5.2.3. Уурхайн малталтын нурал, даралт, гал түймэр, тоосжилт, хорт хийн ялгарал, агаарын найрлагыг тодорхойлох шинжилгээ хийх;
- 5.2.4. Уурхайн малталтад хайгуул хийж зураглал гаргах;
- 5.3. Нэрвэгдэгсдийг аврах, анхан шатны тусламж үзүүлэх, ослын голомтоос шилжүүлэх;
- 5.4. Уурхай, уулын үйлдвэрүүдийн гамшгийн эрсдэлийг бууруулахад холбогдох байгууллагатай хамтран ажиллах;
- 5.5. Уурхай, уулын үйлдвэрүүдийн “Аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөө”-г хянах, баталгаажуулах;
- 5.6. Өргөх, татах төхөөрөмжийн ган татлагад туршилт явуулах, тусгаарлагч шүүгч багны засвар, үйлчилгээ, тохируулга хийх, дүгнэлт гаргах;
- 5.7. Уурхай, уулын үйлдвэрүүдийн аврах багт сургалт, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх;
- 5.8. Уурхай, уулын үйлдвэрүүдийн гамшиг ослын судалгаа хийх;
- 5.9. Олон улсын аврах багтай хамтран ажиллах, аврах ажиллагааны туршлага солилцох, бусад арга хэмжээнд оролцох;

#### Зургаа. Ангийн бүтэц зохион байгуулалт

- 6.1. Ангийн бүтэц, зохион байгуулалт, байрлал, орон тоог Онцгой байдлын ерөнхий газрын дарга тогтооно.
- 6.2. Анги нь захирагч, штабын дарга, техник аврах ажиллагааны удирдагчтай байна.
- 6.3. Ангийн эрэн хайх, аврах ажиллагаа явуулах анхан шатны нэгж нь аврах салбар байна.
- 6.4. Ангийн захирагч дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:
- 6.4.1. Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах;
- 6.4.2. Батлагдсан төсөв хөрөнгийг зориулалтын дагуу захиран зарцуулах;
- 6.4.3. Өөрийн эрх хэмжээний хүрээнд хууль тогтоомжид нийцүүлэн тушаал, шийдвэр гаргах;
- 6.4.4. Ангитай холбоотой аливаа асуудлаар санал боловсруулж Онцгой байдлын ерөнхий газрын даргад танилцуулах;
- 6.4.5. Ангийн нэрийн өмнөөс бусад байгууллагатай харилцах, төлөөлөх;
- 6.4.6. Уурхай, уулын үйлдвэрүүдийн “Аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөө”-г батлах;



6.5. Ангийн захирагчийн дэргэд түүнд зөвлөх үүрэг бүхий зөвлөл ажиллана. Зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журам, хурлын дэгийг ангийн захирагч батална.

6.6. Штабын дарга нь цэргийн албаны сахилга дэг журам, ёс зүйг хэрэгжүүлэх бэлтгэл бэлэн байдлыг хангах, дотоод ажлын төлөвлөлт, зохион байгуулалттай холбогдсон асуудал хариуцаж өдөр тутмын үйл ажиллагааг удирдана.

6.7. Техник, аврах ажиллагааны удирдагч нь аврах ажлыг удирдан зохион байгуулах автомашин, техник, багаж хэрэгслийн бэлэн байдлыг хангуулах, аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөөг хянана.

6.8. Анги нь бие бүрэлдэхүүнийг сургах, дадлагажуулах зорилгоор сургалтын уурхайтай байна.

6.9. Анги нь батлагдсан стандартын дагуу техник хэрэгсэл, автомашин, тоног төхөөрөмжөөр хангагдана.

6.10. Анги нь бэлгэдэл, туг, тэмдэг, хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

6.11. Энэ дүрмээр зохицуулагдаагүй асуудлыг онцгой байдлын байгууллагын холбогдох, дүрэм, журам, заавар, стандартаар зохицуулна.



---oOo---